



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БУА-2022/127/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Булган аймаг
2022 он

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр
Утас: 70342580 Цахим хаяг: ankhbayard@audit.gov.mn
Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг: enhtsoodolj@audit.gov.mn
Аудитор: Б.Пүрэвсүрэн
Утас: 70353717 Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

| | |
|----------------------------------------------------------------------------|-----|
| 1. Аудитын санал дүгнэлт | 2-3 |
| 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл..... | 4 |
| 3. Аудитын тайлан | 9 |
| 3.1 Ерөнхий зүйл | 9 |
| 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт | 9 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал | 9 |
| 3.4 Материаллаг байдал | 10 |
| 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга | 11 |
| 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв | 11 |
| 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг..... | 12 |
| 3.8 Аудитын гол асуудал | 13 |
| 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | 13 |
| 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт..... | 13 |
| 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал | 14 |
| 4. Аудитын илрүүлэлт | 14 |
| 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл | 15 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|-------------------------------------------------------------|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-3259
E-mail: bulgan@audit.gov.mn

2022.02.25 № 60
талай _____ ны № _____ т

ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА П.ХИШИГДАВАА ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шүүхийн тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шүүхийн тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

D:\bichig2022A\doc


006020074

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

D:\shiglerog\2022A\root

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|------------|-----------------------------------------------------------------------|-----------------------|-----------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 12,312,303.00 | 2,672,014.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 12,312,303.00 | 2,672,014.00 |
| 354 | Хангамжийн материал | 12,312,303.00 | 2,672,014.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 3,352,798.00 | 1,239,114.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 5,715,505.00 | 1,344,900.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 3,244,000.00 | 88,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 753,793,125.79 | 772,356,502.71 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 753,793,125.79 | 772,356,502.71 |
| 392 | Биет хөрөнгө | 725,467,875.67 | 744,336,252.51 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 645,163,298.71 | 645,163,298.71 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -54,077,327.04 | -81,115,990.56 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 94,600,000.00 | 155,800,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -75,438,889.08 | -90,922,222.24 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 117,769,816.54 | 139,578,991.82 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -50,478,793.26 | -64,378,871.29 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 58,741,494.98 | 62,234,109.98 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -23,039,017.78 | -33,107,611.43 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 16,320,896.46 | 14,778,446.76 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -4,219,603.86 | -4,015,731.24 |
| 39217 | Ном | 126,000.00 | 321,832.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 28,325,250.12 | 28,020,250.20 |
| 39301 | Програм хангамж | 1,825,000.00 | 1,825,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -763,749.88 | -1,068,749.80 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 27,264,000.00 | 27,264,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 766,105,428.79 | 775,028,516.71 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 766,105,428.79 | 775,028,516.71 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 766,105,428.79 | 775,028,516.71 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 633,641,738.98 | 633,641,738.98 |
| 51101 | Өмч: - төрийн | 633,641,738.98 | 633,641,738.98 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | -165,278,512.01 | -156,355,424.09 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -180,331,083.05 | -165,278,512.01 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 15,052,571.04 | 8,923,087.92 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 297,742,201.82 | 297,742,201.82 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 766,105,428.79 | 775,028,516.71 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|------------|----------|---------------------|-----------------------|
|------------|----------|---------------------|-----------------------|

Булган аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | |
|-------------|------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------|-------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,076,111,360.00 | 1,033,454,430.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 69,262,860.00 | 84,279,830.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 69,262,860.00 | 84,279,830.00 |
| 120009 | Бусад орлого | 48,258,000.00 | 664,000.00 |
| 120011 | Борлуулалтын өртөг /ТӨҮГ/ | | |
| 120012 | Эрхийн шимтгэлийн орлого /ТӨҮГ/ | | |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 20,169,440.00 | 83,130,174.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 835,420.00 | 485,656.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,006,848,500.00 | 949,174,600.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,003,348,500.00 | 949,094,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,003,348,500.00 | 949,094,600.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 3,500,000.00 | 80,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,500,000.00 | 00.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,061,058,788.96 | 1,024,531,342.08 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,061,058,788.96 | 1,024,531,342.08 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,041,104,175.17 | 1,009,092,088.20 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 753,615,765.00 | 690,391,545.29 |
| 210101 | Үндсэн цалин | 581,413,436.00 | 533,900,351.47 |
| 210102 | Нэмэгдэл | 122,291,688.00 | 109,424,907.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 22,087,000.00 | 22,389,500.00 |
| 210104 | Урамшуулал | 27,823,641.00 | 24,676,786.82 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 93,962,734.24 | 90,473,999.53 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 63,955,363.83 | 62,824,504.79 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,508,435.00 | 6,975,372.15 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,498,567.00 | 5,513,099.80 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,009,865.00 | 2,700,668.01 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,990,503.41 | 12,460,354.78 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 54,126,108.58 | 54,607,692.31 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,025,782.58 | 4,607,456.31 |
| 210302 | Түлш, халаалт | 45,592,800.00 | 45,592,800.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,507,526.00 | 4,407,436.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 52,282,978.39 | 59,457,208.54 |
| 210401 | Бичиг хэрэг | 18,633,886.00 | 19,830,684.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 10,644,000.00 | 16,444,900.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 10,654,424.39 | 8,577,200.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 55,000.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 690,000.00 | 645,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 11,605,668.00 | 13,959,424.54 |
| 2105 | Нормативт зардал | 800,000.00 | 800,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 800,000.00 | 800,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 12,156,350.00 | 18,642,500.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 660,600.00 | 3,325,650.00 |

Булган аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | |
|-------------|----------------------------------------------------------------------|----------------------|----------------------|
| 210604 | Урсгал засвар | 11,495,750.00 | 15,316,850.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 3,842,800.00 | 7,007,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,842,800.00 | 7,007,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 5,075,412.00 | 8,891,500.45 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,244,400.00 | 7,115,518.95 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324,000.00 | 00.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,162,000.00 | 1,162,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 229,565.00 | 257,677.50 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 66,000.00 | 66,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 49,447.00 | 42,804.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 65,242,026.96 | 78,820,642.08 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,250,100.00 | 00.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 63,991,926.96 | 78,820,642.08 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 19,954,613.79 | 15,439,253.88 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 4,000,000.00 | 4,998,600.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,000,000.00 | 4,998,600.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 15,954,613.79 | 10,440,653.88 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 15,954,113.79 | 10,440,653.88 |
| 213304 | Хөрөнгийн | | |
| 213305 | Нэмэлт төвлөрүүлэх шилжүүлэг | 500.00 | |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 15,052,571.04 | 8,923,087.92 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 15,052,571.04 | 8,923,087.92 |

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|-----|-----------------------------------------------|---------------------------------|-----------------------|-------------------|-----------------------------------------|
| C01 | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 633,641,738.98 | 297,742,201.82 | -180,331,083.05 | 751,052,857.75 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 633,641,738.98 | 297,742,201.82 | -180,331,083.05 | 751,052,857.75 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 15,052,571.04 | 15,052,571.04 |
| C08 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 633,641,738.98 | 297,742,201.82 | -165,278,512.01 | 766,105,428.79 |
| D01 | 2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 633,641,738.98 | 297,742,201.82 | -165,278,512.01 | 766,105,428.79 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 633,641,738.98 | 297,742,201.82 | -165,278,512.01 | 766,105,428.79 |

Булган аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | | | |
|-----|--------------------------------------------------|-----------------------|-----------------------|------------------------|-----------------------|
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 8,923,087.92 | 8,923,087.92 |
| D09 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 633,641,738.98 | 297,742,201.82 | -156,355,424.09 | 775,028,516.71 |

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 1,006,848,500.00 | 949,174,600.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,006,848,500.00 | 949,174,600.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,003,348,500.00 | 949,094,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,003,348,500.00 | 949,094,600.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 3,500,000.00 | 80,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,500,000.00 | |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 80,000.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 999,009,600.00 | 934,920,755.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 999,009,600.00 | 934,920,755.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 979,054,986.21 | 919,481,501.12 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 753,615,765.00 | 690,391,545.29 |
| 210101 | Үндсэн цалин | 581,413,436.00 | 533,900,351.47 |
| 210102 | Нэмэгдэл | 122,291,688.00 | 109,424,907.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 22,087,000.00 | 22,389,500.00 |
| 210104 | Урамшуулал | 27,823,641.00 | 24,676,786.82 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 93,962,734.24 | 90,473,999.53 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 63,955,363.83 | 62,824,504.79 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,508,435.00 | 6,975,372.15 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,498,567.00 | 5,513,099.80 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,009,865.00 | 2,700,668.01 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,990,503.41 | 12,460,354.78 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 54,126,108.58 | 54,607,692.31 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,025,782.58 | 4,607,456.31 |
| 210302 | Түлш, халаалт | 45,592,800.00 | 45,592,800.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,507,526.00 | 4,407,436.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 56,701,716.39 | 48,819,113.54 |
| 210401 | Бичиг хэрэг | 19,391,564.00 | 17,486,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12,769,000.00 | 12,624,900.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 10,654,424.39 | 8,577,200.00 |
| 210404 | Ном хэвлэл | 55,000.00 | 0.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 690,000.00 | 645,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 13,141,728.00 | 9,486,013.54 |
| 2105 | Нормативт зардал | 800,000.00 | 800,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 800,000.00 | 800,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 9,680,350.00 | 18,490,650.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 660,600.00 | 3,325,650.00 |
| 210604 | Урсгал засвар | 9,019,750.00 | 15,165,000.00 |

Булган аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | |
|-------------|----------------------------------------------------------------------------|----------------------|-----------------------|
| 2107 | Томилолт, зочны зардал | 3,842,800.00 | 7,007,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,842,800.00 | 7,007,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 5,075,412.00 | 8,891,500.45 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,244,400.00 | 7,115,518.95 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,162,000.00 | 1,162,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 229,565.00 | 257,677.50 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 66,000.00 | 66,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 247,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 49,447.00 | 42,804.00 |
| | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,250,100.00 | 0.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,250,100.00 | 0.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 19,954,613.79 | 15,439,253.88 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 4,000,000.00 | 4,998,600.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,000,000.00 | 4,998,600.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 15,954,613.79 | 10,440,653.88 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 15,954,113.79 | 10,440,653.88 |
| 213304 | Хөрөнгийн | | |
| 213305 | Нэмэлт төвлөрүүлэх шилжүүлэг | 500.00 | 0.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 7,838,900.00 | 14,253,845.00 |
| 140008 | Хүлээн авсан ногдол ашиг | 00.00 | 00.00 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 7,838,900.00 | 14,253,845.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 7,838,900.00 | 14,253,845.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 7,838,900.00 | 14,253,845.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 7,838,900.00 | 14,253,845.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | -7,838,900.00 | -14,253,845.00 |
| | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | 0.00 |
| ЭХ.ДТ(31) | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 0.00 |
| ЭЦ.ДТ(31) | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 0.00 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|-----------------------|---------------------------------------------------------|-----------------------|-----------------------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 949,094,600.00 | 938,653,946.12 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 949,094,600.00 | 938,653,946.12 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 944,094,600.00 | 933,655,346.12 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 697,397,800.00 | 690,391,545.29 |
| 210101 | Үндсэн цалин | 575,443,800.00 | 533,900,351.47 |
| 210102 | Нэмэгдэл | 84,343,800.00 | 109,424,907.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 23,346,100.00 | 22,389,500.00 |
| 210104 | Урамшуулал | 14,264,100.00 | 24,676,786.82 |

Булган аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | |
|-------------|----------------------------------------------------------------------|-----------------------|-----------------------|
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,613,400.00 | 12,460,354.78 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 54,633,000.00 | 54,607,692.31 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,625,800.00 | 4,607,456.31 |
| 210302 | Түлш, халаалт | 45,592,800.00 | 45,592,800.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,414,400.00 | 4,407,436.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 48,819,200.00 | 48,819,113.54 |
| 210401 | Бичиг хэрэг | 17,486,000.00 | 17,486,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12,566,000.00 | 12,624,900.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 8,577,200.00 | 8,577,200.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 690,000.00 | 645,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 9,500,000.00 | 9,486,013.54 |
| 2105 | Нормативт зардал | 800,000.00 | 800,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 800,000.00 | 800,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 32,665,000.00 | 32,664,495.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 17,500,000.00 | 17,499,495.00 |
| 210604 | Урсгал засвар | 15,165,000.00 | 15,165,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 7,017,100.00 | 7,007,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,017,100.00 | 7,007,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 9,012,600.00 | 8,891,500.45 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 7,149,200.00 | 7,115,518.95 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,162,000.00 | 1,162,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 325,900.00 | 257,677.50 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 75,000.00 | 66,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 247,500.00 | 247,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 53,000.00 | 42,804.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 5,000,000.00 | 4,998,600.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 5,000,000.00 | 4,998,600.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,000,000.00 | 4,998,600.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 949,094,600.00 | 938,653,946.12 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 949,094,600.00 | 938,653,946.12 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 949,094,600.00 | 938,653,946.12 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | | |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 36.00 | 36.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 05.00 | 05.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 27.00 | 26.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 04.00 | 05.00 |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 36.00 | 36.00 |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 15.00 | 15.00 |
| 650002 | Төрийн тусгай албан хаагч (ТТ) | 11.00 | 10.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 10.00 | 11.00 |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|------------|------------------------------------------------------------------------------|----------|-----------|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | | 80,000.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | | 80,000.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 80,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | | 80,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 80,000.00 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 0.00 | 80000.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | 80,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 80,000.00 |

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Булган аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь “Бэйкер Тилли Далайван Аудит” ХХК-ийн аудитор Б.Пүрэвсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 09 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

1936 онд Богд хан уул аймгийн Булган хан уулын хошууны Тамгын толгой гэдэг газар “Хошууны шүүх” гэж байгуулагдан Сэлэнгэ аймагт харъяалагдан шүүхийн дарга, нарийн бичгийн дарга, байцаагч гэсэн 3 орон тоотой ажиллаж эхэлснээр Булган аймгийн шүүхийн түүхийн хуудас нээгджээ. Булган аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх, Булган аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүх, Булган аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Булган аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд нийт 10 шүүгч, 26 шүүхийн захиргааны ажилтан 65 мянган хүн амтай тус аймгийн 16 сум, 1 тосгоныг харъяалан шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж байна.

Булган аймаг дахь шүүхийн тамгын газар нь өмнөх жилүүдийн ололтыг бататгах, шүүхийн тухай хууль тогтоомж, түүнтэй холбогдон гарах дүрэм, журмын шинэчлэлд үр нөлөөтэй санал, судалгааг гарган ШЕЗ-д хүргүүлэх, тэдгээрийн хэрэгжилтийг хариуцлагатай зохион байгуулах, шүүн таслах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, иргэдэд хүргэх шүүхийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангах, мэдээллийн цахим болон биет орчинг сайжруулж, мэдээллийн үр нөлөөг нэмэгдүүлэх зорилтуудыг 2021 оны тэргүүлэх зорилт болгон дэвшүүлсэн. Тус тамгын газар нь 2021 онд 949,1 сая төгрөгийн төсөвтэйгөөр анхан болон давж заалдах шатны 10 шүүгч, 26 захиргааны ажилтны хүний нөөцөөр 1391 хэрэг, маргааныг анхан болон давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэж төрийн санд 43.289.909 төгрөг орууллаа.

Тодруулбал, анхан шатанд эрүүгийн 242, иргэний 587, захиргааны 28 хэрэг нийт 857 хэрэг, маргааныг хянан шийдвэрлэж, 534 зөрчлийн хэрэгт шийтгэл оногдуулсан байна.

Давж заалдах шатны шүүх эрүүгийн 45, иргэний 16, зөрчлийн 14 хэрэг хүлээн авч, нийт 71 хэрэг, маргааныг хянан шийдвэрлэв.

Шүүхийн үйлчилгээний нээлттэй байдал, мэдээллийн цахим болон биет орчныг нэмэгдүүлэх хүрээнд иргэдэд үйлчлэх орчин нөхцөлийг сайжруулан, шүүхэд хүлээн авах гомдол, нэхэмжлэлийн загвар, зааврыг цахим болон цаасан сангийн хэлбэрээр нээлттэй байршуулж, иргэдэд “шүүхэд мэдүүлэх эрх”-ээ үр нөлөөтэй эдлэх боломжийг бүрдүүлсэн.

Хэргийн хөдөлгөөний удирдлагын хүрээнд хэргийн хөдөлгөөний бүртгэл хяналтын систем болон холбогдох хууль, тогтоомж, дүрэм журам, хэргийн хөдөлгөөний аргачлалыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, системийн алдаа, зөрчлийг бууруулж ажилласан.

2021 онд 242 өргөдөл хүлээн авснаас 159 маргаан шийдвэрлэсний 51.2 хувь нь эвлэрэл амжилттай болж шүүхийн ажлын ачааллыг 21.1 хувиар бууруулсан.

Шүүхийн шинэтгэлийн үйл ажиллагааг олон нийтэд ил тод, хүртээмжтэй, шуурхай мэдээлж, хэвлэл мэдээллийн байгууллагатай тогтмол хамтран ажиллахын зэрэгцээ, “Шүүхэд итгэх иргэдийн итгэл” санал асуулгыг улирал тутам тогтмол авч, ШЕЗ-өөс ирүүлсэн “Шүүхээр үйлчлүүлсэн болон үйлчлүүлээгүй иргэд”-ийн судалгааг жилд 1 удаа, шүүгч ажилтны хэрэгцээ шаардлагыг судлах үндсэн дээр “Санал асуулгын хуудас”-аар санал авч, дүн шинжилгээ хийж байв.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг 14 887.8 мянган төгрөг гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 992 524.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 14 887.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 60 хувиар буюу 8 932.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Булган аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8 923.1 мянган төгрөгөөр буюу 1.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлттэй гарсан нь үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---------------------------------------------------|------------------|------------------|------------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 00.0 | 00.0 | 00.0 |
| Авлага | 00.0 | 00.0 | 00.0 |
| Бараа материал | 12,312.3 | 2,672.0 | 9,640.3 |
| Үндсэн хөрөнгө | 753,793.1 | 772,356.5 | (18,563.0) |
| Нийт хөрөнгө | 766,105.4 | 775 028.5 | (8,923.1) |
| Өр төлбөр | 00.0 | 00.0 | 00.0 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 633,641.7 | 633,641.7 | 00.0 |
| Дахин үнэлгээний зөрүү | 297,742.2 | 297,742.2 | 00.0 |
| Хуримтлагдсан үр дүн | (165,278.5) | (156,355.4) | 8,923.1 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 766.105.4 | 775 028.5 | (8,923.1) |

Бараа материалын данс 2,672.0 мянган төгрөг болж 9,640.3 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны зөвлөмжөөр "тайлант хугацааны эцэст хөрөнгийн нөөц үүсгэсэн түлш шатах тослох материал, бичиг хэргийн материалын үлдэгдэл өмнөх оны үлдэгдлээс өссөн байна" гэсэн зөвлөмж авч хэрэгжүүлэн ажилласантай холбоотой байна. Тайлангийн хугацаанд 17 486.0 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 27 691.1 мянган төгрөгийн аж ахуйн материал, 13 288.9 мянган төгрөгийн шатах тосох материал нийт 58 466.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авч 19 830.6 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 32 316.3 мянган төгрөгийн аж ахуйн материал, 16 444.9 мянган төгрөгийн шатах тосох материал нийт 68 591.9 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан байна. Мөн 485.6 мянган төгрөгийн бичиг хэрэг, аж ахуйн материал шилжүүлэн авсан байна.

Үндсэн хөрөнгө дансанд тайлангийн хугацаанд шүүхийн ерөнхий зөвлөлөөс 62 000,0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 3492.6 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 195.0 мянган төгрөгийн ном эмхэтгэл нийт 83 130.1 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлэн авч, 14 253,8 мянган төгрөгийн компьютер принтер түүний дагалдах хэрэгслийг төсвийн хөрөнгөөр худалдан авч, 800.0 мянган төгрөгийн мотоцикл, 9 886.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж нийт 12 228.8 мянган төгрөгийн хөрөнгө тушаал шийдвэрийн дагуу акталсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 633 641.7 мянган төгрөг хэвээр, өмнөх үеийн үр дүн (165 278.5) мянган мянган төгрөгийн алдагдалтай байсан ба тайлангийн хугацаанд 8 923.0 мянган төгрөгийн ашигтай ажиллаж хуримтлагдсан үр дүн (156 355.4) мянган мянган болсон.

Булган аймаг дахь Шүүхийн тамгын газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт санхүүжилтийн орлого өмнөх оноос 54 253.9 мянган төгрөгөөр буюу 5.7 хувиар буурч, нийт зардал өмнөх оноос 39 527.4 мянган төгрөгөөр буюу 3.8 хувиар тус тус буурсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Булган аймаг дахь Шүүхийн тамгын газар нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 992 524,6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 992 524.6 мянган төгрөгөөр тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Тус байгууллагаас хүргүүлсэн төсвийн төслийг 43 430.0 мянган төгрөгөөр бууруулан 938 653.9 мянган төгрөгөөр баталсан байна. Тайлант онд төсвийг 3 удаа тодотгол хийж 10 440.7 мянган төгрөгөөр өсгөж, 949 094.6 мянган төгрөгөөр баталжээ. Нэг шүүгчийн орон тоо дутуу цалин 9,11 сард татуулсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр 949,094.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, өөрийн үйл ажиллагаанаас 80.0 мянган төгрөг, урсгал үйл ажиллагаанд 938,653.9 мянган төгрөгийг зарцуулж, 10,440.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 533 900.5 мянган төгрөг буюу 98.6 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 7 006.2 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 3 275.9 мянган төгрөг, дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Үндсэн үйл ажиллагааны хүрээнээс 80.0 мянган төгрөгийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авсан байна.

Үүнээс 80.0 мянган төгрөгийг багаж техник хэрэгсэлд зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудитын хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

"Тайлант хугацаанд зарцуулалтыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан боловч, зарим нэгэн зардлууд байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад зориулан албан ажлын зайлшгүй шаардлагаар бүлэг дотор нь гүйлгэн зарцуулсан, бүлгийн дүн дотроо төсөв хэтрээгүй боловч Бодлогын баримт бичгийн дансны төлөвлөгөөний дагуу зардлыг тайлагнаагүй засварын материал, эм бэлдмэл аж ахуйн материал, тусгай зориулалтын материал зэргийг нэг дансанд зарлагдаж тайлагнадаг байна. Мөн 2-3 жил ашигладаг материалын төрлийн эд зүйлсийг тухайн тайлангийн хугацаанд худалдан аваад бараа материалын үлдэгдэлгүй байх үүднээс шууд зарлагдаж байна. Ашиглагдаж байгаа бараа материалыг дансанд нь бүртгэлтэй байлгаж ашиглахаа болсон тохиолдолд акталж устгах ёстой

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Булган аймаг дахь Шүүхийн тамгын газар нь 2021 онд нийт 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулах ёстойгоос хуулийн хугацаанд мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Санхүүгийн тайланд Бараа материалыг бүртгэхдээ нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт болон Сангийн сайдын 2006 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 388 тоот тушаалаар батлагдсан журмын дагуу бүртгэж тайлагнадаггүй аж ахуйн материалд бүх материалыг хольж бүртгэдэг ба материалын зардлыг мөн адил Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ны 190 тоот тушаалаар батлагдсан журмын дагуу бүртгэж тайлагнаагүй байна. Аудитын явцад бүртгэлтэй холбоотой зөвлөмж зөвлөгөөг өгч ажилласан болно.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 9 094,9 мянган төгрөгийн 4 зөвлөмжийн хэрэгжилтийг 100 хувьтай хангуулсан байна.

Хүснэгт . Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|-----------------|---------------------|---------|---------|---------|-------|-----|------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | - | - | - | - | - | - | |
| Албан шаардлага | - | - | - | - | - | - | |
| Зөвлөмж | 4 | 9 094,9 | 4 | 9 094,9 | - | - | |
| Нийт дүн | 4 | 9 094,9 | 4 | 9094,9 | - | - | |

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар бараа материалын ангилал, зардлын ангилал дээр анхаарч ажиллах бөгөөд бусад чухал асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар тоон мэдээлэлгүй нэг зөвлөмж авсан ба шаардлагатай зүйлсийг аудитын явцад зөвлөж ажилласан болно.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад залруулсан алдаа байхгүй.

4.2 Акт

Аудитын явцад акт байхгүй.

4.3 Албан шаардлага

Албан шаардлага хүргүүлэх хэмжээний алдаа зөрчил гаргаагүй болно.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Бараа материалын дансанд хангамжийн материал, аж ахуйн материал, хүнс, тусгай зориулалтын материал, эм бэлдмэл зэрэг бүх төрлийн материалыг нэг дансанд бүртгэж тайлагнаж байна. Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 2-р хавсралт болон байгууллагын бодлогын баримт бичигт заасан бараа материалын дансны ангиллын дагуу бараа материалыг ангилан бүртгэж байхыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Бараа материалын дансанд хангамжийн материал, аж ахуйн материал, хүнс, тусгай зориулалтын материал, эм бэлдмэл зэрэг материалыг тус бүрийн дансанд салгаж бүртгэх .

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|-----|----------------------------------------|----------------------|------------------|-----------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|------------------|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Булган аймаг дахь Шүүхийн тамгын газар | 1 | Тоон мэдээлэлгүй | | | | | | | 1 | Тоон мэдээлэлгүй |

АУДИТЫН ТАЙЛАНГ

БЭЛТГЭСЭН:

“БЕЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ” ХХК-ИЙН ОРХОН АЙМАГ ДАХЬ САЛБАРЫН

АУДИТОР:



Б.ПҮРЭВСҮРЭН

ХЯНАСАН:

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР, ЗАХИРАЛ :




Д.МЯГМАРСҮРЭН

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

АУДИТЫН МЕНЕЖЕР:




Ж.ЭНХЦООДОЛ

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Д.АНХБАЯР

